

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САНГААС ТЭТГЭЛЭГ ОЛГОХ,  
САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 18.5 дахь хэсэгт заасан шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, тэтгэлэг олгох, дэмжлэг үзүүлэх үндсэн зарчмыг тогтоох, тэдгээртэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Журмын 1.1-д заасан үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Засгийн газрын тусгай сангийн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Инновацын тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

1.3. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсанаар ойлгоно. Үүнд:

1.3.1. "шинжлэх ухаан, технологийн төсөл (цаашид "төсөл" гэх)" гэж Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасныг;

1.3.2. "судалгаа хөгжүүлэлтийн ажил" гэж Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасныг;

1.3.3. "үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөл" гэж Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасныг;

1.3.4. "суурь судалгаа" гэж Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д заасныг;

1.3.5. "хэрэглээний судалгаа" гэж Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д заасныг;

1.3.6. "технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажил" гэж Инновацын тухай хуулийн 3.1.10-т заасныг;

1.3.7. "судалгааны грант" гэж Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д заасныг;

1.3.8. "докторын дараах судалгаанд олгох сайдын нэрэмжит инновацын тэтгэлэг" гэж докторын зэрэг хамгаалсан залуу судлаачид бие даан хийх судалгаа, туршилт, зохион бүтээх ажлыг нь дэмжиж олгох буцалтгүй дэмжлэгийг;

1.3.9. "сайдын нэрэмжит залуу судлаачдын грант" гэж залуу судлаачид эрдмийн зэрэг хамгаалах бүтээлээ боловсруулах, судалгааны онол, арга зүй, туршилт, үйлдвэрлэлийн үр дүнгээ бататгахад зориулан олгох буцалтгүй дэмжлэгийг;

1.3.10. "шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа" Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасныг;

1.3.11. "итгэмжлэн хадгалагч" гэж шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр батлагдсан, эрдэм шинжилгээний ажлын тайланг архивлан хадгалах, түүний мэдээллийн нууцыг хамгаалах, төслийн үр дүн, шинэ мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх үүрэг бүхий байгууллага буюу санг;

1.4. Энэхүү журмын 1.3-т заасан төслийг хэрэгжүүлэхдээ Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан(цаашид "сан" гэх)-аас тэтгэлэг олгох, дэмжлэг үзүүлэх хэлбэрээр санхүүжүүлэх бөгөөд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.1.1-д заасан эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

1.5. Төсөл хэрэгжүүлэхдээ шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлд хамаарах төслийг тэргүүн ээлжинд дэмжин хэрэгжүүлэх бөгөөд ил тод, нээлттэй байх, үр ашигтай байх, тэгш өрсөлдөх боломжтой байх үндсэн зарчмыг баримтална.

### **Хоёр. Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, тэтгэлэг олгох, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт**

2.1. Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэхдээ тэтгэлэг олгох, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг дараах байдлаар удирдан зохион байгуулна. Үүнд:

2.1.1 Төсөл нь дараах төрөлтэй байна:

2.1.1.1. үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөл;

2.1.1.2. суурь судалгааны төсөл;

2.1.1.3. хэрэглээний судалгааны төсөл;

2.1.1.4. технологийн туршилт зүгшрүүлэлтийн төсөл;

2.1.1.5. гадаадтай хамтарсан төсөл

2.1.1.6. судалгааны тэтгэлэг(докторын дараах), грант (залуу судлаачдын грант);

2.1.2 Тэтгэлэг, дэмжлэгийг энэхүү журмын 2.1.1-д заасан төсөл, судалгааны тэтгэлэг, грант болон шинжлэх ухаан, технологийн дараах үйл ажиллагаанд олгоно:

2.1.2.1. эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх;

2.1.2.2. инновацын төсөл хэрэгжүүлэх;

2.1.2.3. гарааны санхүүгийн дэмжлэг олгох;

2.1.2.4. технологи, үйлдвэрлэлийн туршилт, зүгшрүүлэлтэд дэмжлэг үзүүлэх;

2.1.2.5. олон улсын хамтын ажиллагаа болон гадаад улс, олон улсын байгууллагатай хамтарсан судалгаанд дэмжлэг үзүүлэх;

2.1.2.6. шинжлэх ухаан, технологийн хүний нөөц болон шинжлэх ухааны

авьяастныг бэлтгэх, хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих;

2.1.2.7. шинжлэх ухаан, инновацын үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлэх.

2.2. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах Мэргэжлийн хороо (цаашид "Хороо" гэх)-ны гишүүдийг Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн мэдээллийн системээс тусгай шаардлага, шалгуур үзүүлэлтээр сонгон авч, Шинжлэх ухаан технологийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.

2.3. Хууль болон Засгийн газрын шийдвэрээр тусгайлан зааснаас бусад тохиолдолд Сангаас энэ журмын 2.1-д заасан санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, хуулиар тогтоосон бусад санхүүгийн дэмжлэг үзүүлэх шийдвэрийг Мэргэжлийн хорооны сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

2.4. Энэхүү журмын 2.1.1-д заасан төслийг сонгон шалгаруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах үе шаттай байна:

2.4.1. нээлттэй зарлах, захиалах;

2.4.2. төслийн санал мэдүүлэх;

2.4.3. давхардал, хуулбарлалт шалгах;

2.4.4. шинжээч томилох;

2.4.5. сонгон шалгаруулах;

2.4.6. сонгон шалгаруулалтын үр дүнг баталгаажуулж, шийдвэр гаргах;

2.4.7. гэрээ байгуулж, санхүүжүүлэх;

2.4.8. хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд хяналт тавих;

2.4.9. үр дүнг мэдээлэх, тайлагнах, баталгаажуулах;

2.4.10. үр дүнг хүлээлгэн өгөх, санхүүгийн тооцоо нийлэх;

2.5. Төслийн захиалагч (цаашид "захиалагч" гэх) нь төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн байна.

2.6. Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага нь дангаар болон аж ахуйн нэгжтэй хамтран төсөл захиалж болно.

2.7. Гадаадтай хамтарсан төслийг гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах гэрээ (хэлэлцээр)-нд заасны дагуу хэрэгжүүлнэ.

2.8. Төслийн гүйцэтгэгч нь эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, судлаачдын баг, Монгол Улсын харьяалалтай иргэн, судлаач байна.

2.9. Төслийн удирдагч (цаашид "Удирдагч" гэх) нь докторын зэрэгтэй байна. Удирдагчийг гүйцэтгэгчийн хүсэлтээр захиалагчтай зөвшилцөн өөрчилж болно.

Удирдагчид олгох нэмэгдэл цалин, урамшууллын хэмжээг төсөл хэрэгжүүлэх гэрээнд заасан байна.

2.10. Захиалагчийн санал нь дор дурдсан бүрдэлтэй байна:

2.10.1. шийдвэрлүүлэх асуудлын нэр, сэдэв;

2.10.2. үндэслэл, хэрэгцээ шаардлага, судлагдсан байдал;

2.10.3. үр дүнг хүлээн авах хугацаа;

2.10.4. захиалагчаас санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээ;

2.10.5. үр дүнгийн даалгавар, шалгуур үзүүлэлт;

2.10.6. үр дүнг нэвтрүүлэх, ашиглах, борлуулахад захиалагчийн хүлээх үүрэг, хариуцлага;

2.10.7. үр дүнг нэвтрүүлж ашигласнаас олох эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын талаарх төсөөлөл.

2.11. Захиалагч нь дараа оноос хэрэгжүүлэх журмын 2.1.1.1-д заасан үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төслөөр шийдвэрлүүлэх асуудлыг тодорхойлж, энэ журмын 2.10-т заасан бүрдлийг ханган Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу боловсруулж, тухайн оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.12. Энэ журмын 2.2-т заасан мэргэжлийн хороо нь 2.10-т заасан захиалагчийн төслийн саналыг жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хэлэлцэн дүгнэлт гаргаж, дэмжигдсэн захиалагчийн санал, шийдвэрлүүлэх асуудлын сэдвийг 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй зарлана. Төслийн саналыг хэлэлцэхэд захиалагчийн төлөөллийг саналын эрхтэйгээр оролцуулна.

2.13. Энэхүү журмын 2.12-т заасан салбар зөвлөлөөр дэмжигдсэн захиалагчийн санал, шийдвэрлүүлэх асуудлын сэдвийг Шинжлэх ухаан, технологи, инновацийн Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ.

2.14. Энэ төслийн гүйцэтгэгч нь төслийн саналаа журмын 2.11-т заасны дагуу тогтоосон хугацаанд цахим хэлбэрээр санд хүргүүлнэ.

2.15. Энэ журмын 2.1.1.1-2.1.1.4, 2.1.1.6-д заасан төслийг тухайн жилийн 01 дүгээр сард багтаан хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй зарлана. Төслийн гүйцэтгэгч нь төслийн саналаа 02 дугаар сард багтаан санд шаардлагын дагуу цахимаар мэдүүлнэ.

2.16. Энэ журмын 2.1.1.1-2.1.1.4, 2.1.1.6-д заасан төслийг 2.8-д заасан оролцогчид дэвшүүлнэ.

2.17. Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь гадаад улс, олон улсын байгууллагатай байгуулсан гэрээнд заасан

хугацаанд багтаан энэхүү журмын 2.1.1.5-д заасан төслийн болзол, нөхцөлийг зарлана.

2.18. Төслийн удирдагч нь төслийн баримт бичгийг зарласан болзол, шаардлагын дагуу боловсруулж, шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Санд тогтоосон хугацаанд цахим хэлбэрээр мэдүүлнэ.

2.19. Төслийн баримт бичиг нь дор дурдсан бүрдэлтэй байна:

- 2.19.1. төслийн нэр;
- 2.19.2. хугацаа (эхлэх, дуусах он, сар);
- 2.19.3. захиалагч (дэвшүүлэгч);
- 2.19.4. гүйцэтгэгч байгууллага;
- 2.19.5. санхүүжүүлэх этгээд;
- 2.19.6. нийт зардал;
- 2.19.7. удирдагчийн овог, нэр, регистрийн дугаар, албан тушаал, мэргэжил, боловсролын болон эрдмийн зэрэг, цол;
- 2.19.8. оролцогчдын овог, нэр, регистрийн дугаар, албан тушаал, мэргэжил, боловсролын болон эрдмийн зэрэг цол, төсөлд тэдний оролцох хэлбэр (үндсэн болон туслан гүйцэтгэгч, гэрээгээр ажиллах гэх мэт);
- 2.19.9. гүйцэтгэх үндэслэл, шаардлага;
- 2.19.10. урьдчилсан судалгаа хийгдэж судлагдсан байдал;
- 2.19.11. эцсийн үр дүнгийн талаарх төсөөлөл, шинэлэг, дэвшилттэй тал;
- 2.19.12. эдийн засаг, нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол;
- 2.19.13. зорилт, төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө;
- 2.19.14. үр дүнг шилжүүлэх, борлуулах, ашиглах боломж, төслийн өртгийг нөхөх урьдчилсан тооцоо, хугацаа (бусдад худалдах, лицензийн гэрээгээр ашиглуулах, төслийг санаачлагч өөртөө үлдээх гэх мэт);
- 2.19.15. өртөг зардлыг тооцсон товчоо, түүний задаргаа, захиалагчаас гаргах хөрөнгийн хэмжээ, холбогдох бусад материал;
- 2.19.16. лаборатори, туршилтын бааз;
- 2.19.17. үр дүнг хүлээлгэн өгөх, хянан магадлагаа хийлгэх, нэвтрүүлэхэд шаардагдах хөрөнгийн урьдчилсан тооцоо;
- 2.19.18. гүйцэтгэгч байгууллагаас төсөл хэрэгжүүлэхийг дэмжсэн албан бичиг.

2.20. Энэ журмын 2.12, 2.14-т заасан төслийн саналын бүрдэл, агуулга, үр дүнг, даалгаврын давхардал, гүйцэтгэгч, удирдагчийн өмнө нь хэрэгжүүлсэн төслийн гүйцэтгэлийг Сан хяналт тавина.

2.21. Өмнө хэрэгжүүлсэн төслийн үр дүнг гэрээнд заагдсан хугацаанд хүлээлгэн

өгөөгүй гүйцэтгэгч, төслийн удирдагч, мөн иж бүрдэл дутуу, шаардлага хангаагүй төсөл, саналыг сонгон шалгаруулалтад оруулахгүй.

2.22. Төслийн санал тус бүрд гурван мэргэжлийн шинжээч /цаашид “Шинжээч” гэх/-ийг “төслийн удирдлагын систем”-ээс сонгон авч ажиллуулах шийдвэрийг Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн Ажлын албаны дарга гаргана.

2.23. Шинжээч нь төслийн саналд үнэлгээ өгч, дүгнэлт гаргахдаа шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлалыг мөрдлөг болгон ажиллана.

2.24. Санхүүгийн хувьд хянан магадлах шаардлагатай гэж үзсэн саналд санхүүгийн шинжээч томилон ажиллуулж болно.

2.25. Сангаас шинжээчийн олонхын саналаар дэмжигдсэн төслийн саналыг дараагийн шатны сонгон шалгаруулалтад оролцуулахаар Мэргэжлийн хороонд хүргүүлэх бөгөөд төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг төслийн удирдагч биечлэн танилцуулна. Удирдагч хүндэтгэн үзэх шалтгаанаар танилцуулах боломжгүй тохиолдолд багийн гишүүн танилцуулж болно.

2.26. Мэргэжлийн хороо нь шинжээчийн үнэлгээ, төслийн талаарх мэдээллийг үндэслэн үнэлгээ, дүгнэлт гаргах бөгөөд Мэргэжлийн хорооны нийт гишүүдийн олонхын санал авсан төслийн санал, дүгнэлтийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна. Шинээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.27. Энэхүү журмын 2.26-д заасан Мэргэжлийн хорооны шалгаруулсан төслийн саналын үр дүнгийн даалгавар, төсөвт өртгийг сан хянан магадалж, санхүүжүүлэх саналыг шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан нэгжтэй хамтран хянана.

2.28. Энэхүү журмын 2.1.2-т заасан сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээний жагсаалт, санхүүжилтийн хэмжээ, хэлбэрийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.29. Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь төслүүдийн сонгон шалгаруулалтыг тухайн оны эхний хагас жилд багтаан энэхүү журамд заасны дагуу явуулна. Төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн төсвийн саналыг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.

2.30. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.7-д заасны дагуу сан нь сонгон шалгаруулалтыг цахимаар болон олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зарлаж, зохион байгуулах бөгөөд сонгон шалгаруулалтын үе шат бүрд тухайн төслийн шалгаруулалтын явцын талаар төслийн удирдагч нарт цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

2.31. Төрийн болон албаны нууцын зэрэглэлтэй төслийн саналыг шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын нууцын асуудал эрхэлсэн албан тушаалтан шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэр гаргуулна. Энэ төслийн үр дүнг захиалагч бүрэн

хариуцна.

2.32. Төслийн санал болон холбогдох материалын үнэн зөв байдлыг төсөл мэдүүлэгч бүрэн хариуцна.

2.33. Гадаадтай хамтарсан төслийн сонгон шалгаруулалтын дүнг гэрээний гадаад оролцогч талд хүргүүлнэ. Сангийн олон улсын сантай хамтран хэрэгжүүлэхээс бусад талуудын санал нэгдсэн төслийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шинээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг батлуулна.

2.34. Энэхүү журмын 2.33-т заасан Сан сантай хамтран шинээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн Ажлын албаны дарга батална.

### **Гурав. Гэрээ байгуулах, төслийг санхүүжүүлэх**

3.1. Төслийн захиалагч, санхүүжүүлэгч, гүйцэтгэгч (цаашид “талууд” гэх) нь шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан үлгэрчилсэн загварын дагуу гэрээг энэхүү журмын 2.29-т заасан төслийн жагсаалт батлагдсанаас хойш 30 хоногт багтаан байгуулна.

3.2. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон үндсэн хөрөнгийг эзэмших, өмчлөх талаар гэрээнд заавал тусгана.

3.3. Гэрээг 4 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувь хадгална.

3.4. Шинжлэх ухаан, технологийн арга хэмжээнд зарцуулах төсөв хүрэлцэхгүй тохиолдолд шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь захиалагчтай хамтран төслийн хэрэгжилтэд зохицуулалт хийх талаар санал боловсруулж, Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хороогоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлж болно.

3.5. Энэхүү журмын 2.1.1.2-2.1.1.3-т заасан төслийг хэрэгжүүлэх гэрээний хугацаа 3 жил хүртэл, бусад төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээний хугацаа 2 жил хүртэл байна. Төслийн санхүүжилтийг улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хувь хэмжээг тусгаж тухайн гэрээний хугацааг гэрээ байгуулсан өдрөөс эхлэн тооцно.

3.6. Гүйцэтгэгч нь энэхүү журмын 2.1.1-д заасан төслийн гэрээний хугацааг сунгах болон төслийн удирдагчийг солих асуудлыг хүндэтгэн үзэх шалтгаан(*хүндээр өвдсөн, төслийн гүйцэтгэгч нас барсан, байгалийн гамшиг зэрэг давагдашгүй хүчин зүйлс*)-тай тохиолдолд бичгээр, нотлох баримтыг хавсарган хүсэлт гаргах бөгөөд уг асуудлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ. Зөвхөн энэ тохиолдолд төслийн хугацааг 1 хүртэлх жилийн хугацаагаар сунгана.

3.7. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас төслийн удирдагч төслийг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд холбогдох асуудлыг тухайн салбарын Мэргэжлийн хорооны санал, дүгнэлтэд үндэслэн төслийг үргэлжлүүлэх эсэх талаар Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулна.

3.8. Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь сангийн хөрөнгөөс төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгийн хувь хэмжээг Үндэсний хорооны тогтоол, зөвлөмжийг үндэслэн шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

3.9. Аж ахуйн нэгжтэй хамтран хэрэгжүүлэх энэхүү журмын 2.1.1.1, 2.1.1.5-д заасан төслийн санхүүжилтийн төрийн захиргааны төв байгууллагад ногдох хөрөнгийн хувь хэмжээг Үндэсний хорооны тогтоол, зөвлөмжийг үндэслэн шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоож, сангаас санхүүжүүлнэ.

3.10. Төслийн зардал нь дараах бүрдэлтэй байна:

- 3.10.1. судлаачдын цалин хөлс;
- 3.10.2. судалгаа шинжилгээ, сорилт туршилтад шаардагдах материал, эм, урвалж бодис, туршилтын амьтан, нэг удаагийн хэрэглэгдэхүүн худалдан авах зардал;
- 3.10.3. эрдэм шинжилгээний хурал, семинар, үзэсгэлэнгийн зардал;
- 3.10.4. гадаад, дотоод томилолт, гадаадын эрдэмтдийн болон хээрийн судалгааны зардал;
- 3.10.5. багаж, тоног төхөөрөмж, компьютер, сэлбэг хэрэгсэл, программ хангамж худалдан авах, суурилуулах, засвар үйлчилгээ хийлгэх зардал;
- 3.10.6. эрдэм шинжилгээ, патентын мэдээллийн санд хандах болон архив, номын сангийн үйлчилгээний төлбөр;
- 3.10.7. мэргэжлийн үнэлгээнд үндэслэн нийтэлдэг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх төлбөр;
- 3.10.8. Монгол Улсад патент, ашигтай загвар мэдүүлэхтэй холбоотой зардал;
- 3.10.9. судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх зардал;
- 3.10.10. төслийн явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зардал;
- 3.10.11. дээж шинжлүүлэх, социологийн судалгаа хийх, мэдээлэл худалдан авах, хэвлэлийн эх бэлтгэл, хэвлэлт, орчуулга зэрэг бусдаар гүйцэтгүүлэх ажлын төлбөр;
- 3.10.12. түрээсийн зардал.

3.11. Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг түүний төрөл, үр дүнг ашиглах хэлбэр, худалдан борлуулах боломж зэргийг харгалзан дараах хэлбэрээр санхүүжүүлнэ:

- 3.11.1. буцалтгүй хэлбэрээр санхүүжүүлэх;
- 3.11.2. эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэх;

### 3.11.3. төслийн зардлын тодорхой хувийг санхүүжүүлэх.

3.12. Төслийг санхүүжүүлэх хэлбэрийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно. Санхүүжилтийн хэмжээ, хугацаа, хэлбэрийг тухайн төсөл, арга хэмжээг гэрээнд тусгана.

3.13. Төсөл хэрэгжүүлэх явцад үр дүн болон түүний санхүүжилтэд өөрчлөлт оруулах шаардлага гарсан тохиолдолд захиалагч, санхүүжүүлэгч хамтран санал боловсруулж, шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

3.14. Үргэлжлэн хэрэгжиж байгаа төслийн төлөвлөгөөт оны зардлыг тодорхойлохдоо төрийн захиргааны байгууллагаас анх баталсан нийт төсөвт өртгийн тухайн оны хуваарийг үндэслэл болгоно.

3.15. Төслийн төсөвт өртөг, зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих асуудлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.

3.16. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 18.4-т заасны дагуу сангийн хөрөнгөөс санхүүжүүлэн төсөл, арга хэмжээний санхүүжилтээс аливаа татаас, урамшуулал олгох, батлагдсан төсвөөс хэтрүүлэх, бусад холбогдох хууль, энэ журамд зааснаас өөр зориулалтаар ашиглах, бусад үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.

3.17. Энэхүү журмын 2.1.1.6-д заасан тэтгэлэг, грантыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан "Залуу судлаач, эрдэмтэнд грант олгох журам"-ын дагуу тус тус хэрэгжүүлж, санхүүжүүлнэ.

### **Дөрөв. Төслийн хэрэгжилт, гүйцэтгэлд тавих хяналт, үр дүнг хянан магадлах, баталгаажуулах**

4.1. Төслийн арга зүйн түвшин, хэрэгжилтийн явц, хугацаа, үр дүн, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн байдал, санхүүгийн үйл ажиллагаанд шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан нэгж, сан хамтран хяналт тавина. Хяналтын зардал нь төслийн нийт зардлын нэг хувиас хэтрэхгүй байна.

4.2. Шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус шинжээчийн багийг ажиллуулж болно. Шинжээчийн баг нь дүгнэлтийг санд хүргүүлж, шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

4.3. Төслийн гүйцэтгэлийн явц захиалагч, санхүүжүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар удаашрах, үр дүн нь гэрээнд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд захиалагч, санхүүжүүлэгч нь хугацаанаас өмнө гэрээг цуцлах, санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх талаар шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж шийдвэрлүүлнэ.

4.4. Төсөл зарлах, төслийг сонгон шалгаруулах, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнтэй нь танилцах, шинжээч ажиллуулахтай холбогдон гарах зардлыг энэхүү журмын 4.1-д заасан хяналтын зардлаас санхүүжүүлнэ.

4.5. Төслийн үр дүн нь дор дурдсан хэлбэртэй байна:

4.5.1. онолын судалгааны тайлан, онолын үндэслэл, үзэл баримтлал, загвар, нэг сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл;

4.5.2. шинэ болон шинэчилсэн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний загвар;

4.5.3. шинэ болон шинэчилсэн технологи, технологийн заавар;

4.5.4. ашигтай загварын гэрчилгээ, зохиогчийн эрх;

4.5.5. техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, түүний эд анги, туршилтын загвар, ажлын зураг;

4.5.6. үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах техник-эдийн засгийн урьдчилсан судалгаа, үндэслэл, зураг, тооцоо;

4.5.7. судалгаа, туршилт, боловсруулалтын ажил болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах бусад төрлийн заавар, журам, аргачлал, эмчилгээ, оношилгооны шинэ дэвшилтэт арга, зөвлөмж, математик загвар, бодлогын алгоритм, программ хангамж, стандарт, норм, схем;

4.5.8. туршилтын үйлдвэр, цех, үйлчилгээний нэгж.

4.6. Төслийн үр дүнг дор дурдсан баримт бичгүүдээр баталгаажуулна:

4.6.1. мэргэжлийн хянан магадлагаанд үндэслэн нийтэлдэг гадаад, дотоодын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл, нэг сэдэвт бүтээл;

4.6.2. үндэсний болон олон улсын патент;

4.6.3. бүтээгдэхүүний загвар, зохиогчийн эрх, ашигтай загварын гэрчилгээ;

4.6.4. үндэсний болон олон улсын стандарт, норм, норматив;

4.6.5. техник, технологийн баримт бичгийн иж бүрдэл;

4.6.6. захиалагчийн дүгнэлт.

4.7. Шинжлэх ухаан, технологийн судалгаа шинжилгээний үр дүн нь дамжуулах технологид хамаарах бөгөөд байгаль орчин, хүнд үзүүлэх нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс илүү сөрөг нөлөө үзүүлэхүйц технологийг дамжуулахыг хориглоно.

4.8. Захиалагч төслийн үр дүнг гүйцэтгэгчээс хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан шинжээчээр хянан магадлагаа хийлгэж, дээрх үр дүнгээр баталгаажуулаагүй төслийн удирдагчийн цаашид төсөл хэрэгжүүлэх эрхийг хязгаарлах эсэх талаар дүгнэлт гаргуулна.

4.9. Төслийн гүйцэтгэлийг дор дурдсан 2 хэлбэрээр тайлагнана:

4.9.1. гүйцэтгэлийн эцсийн үр дүн, санхүүжилтийн талаар холбогдох хууль, журмын дагуу бичсэн төслийн тайланг захиалагч, санхүүжүүлэгчид тогтоосон хугацаанд нь хүлээлгэн өгөх;

4.9.2. төслийн хүрээнд бий болсон шинжлэх ухааны шинэ мэдлэг (энэ журмын 4.6-д дурдсан баримтаар баталгаажсан)-ийн талаар улсын стандартын дагуу бичсэн эрдэм шинжилгээний ажлын тайланг энэхүү журмын 1.3.11-д заасан “итгэмжлэн хадгалагч”-д төсөл дууссанаас хойш 2 сарын дотор цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэн өгөх;

4.9.3. Төслийн тайланг хүлээлгэн өгөхдөө дараах хурлаар хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсан байна. Үүнд:

4.9.3.1. Журмын 2.1.1.1, 2.1.1.3, 2.1.1.5, 2.1.1.6-д заасан төслийг шинжлэх ухаан, технологи, инновацын салбар зөвлөл;

4.9.3.2. Журмын 2.1.1.2, 2.1.1.4-т заасан төслийг Шинжлэх ухааны академийн салбарын Бага чуулган, төрөлжсөн академи;

4.10. Төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлөх, эзэмших асуудлыг Инновацын тухай хуулийн 27.1-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

4.11. Захиалагч нь сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрхэн нэвтрүүлж ашигласан талаар Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хороонд хоёр жил тутамд тайлагнана.

4.12. Гүйцэтгэгч буюу эрдэм шинжилгээний байгууллага болон ажилтан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш 60 хоногийн дотор эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын тайлан болон эрдэм шинжилгээний ажлын явц, гүйцэтгэл, санхүүжилтийн зориулалтаар олгосон хөрөнгийн зарцуулалтын мэдээ, тайланг захиалагч, санхүүжүүлэгч байгууллагын шаардсанаар тухай бүр үнэн зөв гаргаж өгөөгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасан журмын дагуу холбогдох баримтыг бүрдүүлж, төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлнэ.

#### **Тав. Төслийн үр дүнг хүлээлгэж өгөх, санхүүгийн өр авлагыг барагдуулах, маргаан хянан шийдвэрлэх**

5.1. Гүйцэтгэгч нь төсөл дууссанаас хойш 3 сарын дотор түүний тайлан, үр дүнг захиалагчид актаар хүлээлгэж өгнө. Төслийн үр дүнг хүлээлгэн өгөхдөө шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг үнэлж, хүлээн авсан акт”-ын үлгэрчилсэн загварын дагуу 4 хувь үйлдэж захиалагч, гүйцэтгэгч, санхүүжүүлэгч болон шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тус бүр нэг хувийг хадгалуулна.

5.2. Төслийн захиалагч нь шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 33.2.6-д заасан хугацаанд захиалгат төслийн үр дүнг нэвтрүүлэх, ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлэн, энэ талаар хийсэн ажлын мэдээ, тайланг Үндэсний хороонд тайлагнана.

5.3. Энэхүү журмын 2.1.1.1-д заасан үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төслийн захиалагч, гүйцэтгэгч нь хүлээн авсан үр дүнгээ үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглаагүй эсхүл ашиглах бололцоогүй үр дүн захиалсан бол төсөлд зарцуулсан хөрөнгийг санд

буцаан төлнө. Буцааж төлөөгүй тохиолдолд төсөл захиалах эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж болно.

5.4. Гэрээнд заасан шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр захиалагч төслийн эцсийн үр дүнг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд Мэргэжлийн хорооны дүгнэлт, шийдвэрийг үндэслэн уг ажлыг дахин гүйцэтгүүлэх буюу санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх арга хэмжээг авна. Энэ тохиолдолд тухайн гүйцэтгэгчийн төслийн сонгон шалгаруулалтад оролцох эрхийг 3 жилийн хугацаагаар түдгэлзүүлнэ.

5.5. Төслийн гүйцэтгэгч энэхүү журмын 4.8, 5.1 дэх заалтад заасныг зөрчсөн тохиолдолд уг ажлын удирдагчийн төсөл удирдах эрхийг 3 хүртэл жилийн хугацаагаар түдгэлзүүлнэ.

5.6. Сангийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулахад оролцох албан тушаалтан холбогдох хуульд заасан журмын дагуу ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

5.7. Төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулж, хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч шийдвэрлэнэ. Хэрэв гомдол гаргагч энэ шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

5.8. Монгол Улсын болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хооронд үүссэн хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, технологи дамжуулахтай холбогдсон маргааныг Монгол Улсын олон улсын гэрээ, талуудын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлэнэ.

---oOo---